



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 4/415

Улаанбаатар хот

**Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн
бүртгэл тооллогын ажил зохион
байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалт Нийслэлийн Засаг даргын 2023 оны Б/34 дүгээр захирамж, Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай” А/571, А/48 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн иргэдийн эзэмшилд бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.


2. Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийн шинэчилсэн бүртгэл, тооллогод бүрэн хамруулах, ажлын хэсгийг ажиллах нөхцөл боломжоор хангах, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр гарган өгч хамтран зохион байгуулахыг хорооны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг(Б.Мөнгөнхуяг)-т даалгасугай.


5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Б.Нарангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ЖАРГАЛСҮРЭН

Баянгол дүүргийн Засаг даргын
2023 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн
А/... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт
1/215



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ,
ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга	Б.Мөнгөнхуяг	Баянгол дүүргийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Н.Сумъяа	Баянгол дүүргийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
	М.Ганжигүүр	Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дарга
	Н.Ариунтөгс	Баянгол дүүргийн замын цагдаагийн хэлтсийн дарга
	Г.Батцэцэг	Баянгол дүүргийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Л.Оюунгэрэл	Баянгол дүүргийн ЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах төвийн дарга
	Н.Анхбаяр	Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Баянгол дүүргийн Хорооны Засаг дарга нар	
	Б.Амарлингуй	Баянгол дүүргийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хороо хариуцсан мэргэжилтэн
	Ш.Батмөнх	БГД-ийн Цагдаагийн газрын Замын Цагдаагийн Хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахмад

Баянгол дүүргийн Засаг даргын
2023 оны 09 дугаар сарын 22-ны өдрийн
А/215 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН
БҮРТГЭЛ, ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль болон “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл тооллогод хамруулахад оршино.

Дараах шийдвэрүүдийг удирдлага болгоно. Үүнд:

1. Автотээврийн тухай хууль;
2. Авто замын тухай хууль;
3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль;
4. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль;
5. Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэл;
6. Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах тухай” А/57/47 дугаар тушаал.
7. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналт, үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслийн жагсаалт;
8. Салбарын бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт;

Хороодод хамрагдвал зохих тээврийн хэрэгслийн тоо

Д/д	Хороод	Шинэчилсэн бүртгэл, тооллогод хамрагдах тээврийн хэрэгслийн тоо
1.	1 дүгээр хороо	2798
2.	2 дугаар хороо	2191
3.	3 дугаар хороо	1501
4.	4 дүгээр хороо	2257
5.	5 дугаар хороо	1286
6.	6 дугаар хороо	2031
7.	7 дугаар хороо	990
8.	8 дугаар хороо	1191
9.	9 дүгээр хороо	657
10.	10 дугаар хороо	714
11.	11 дүгээр хороо	658
12.	12 дугаар хороо	977
13.	13 дугаар хороо	1032
14.	14 дүгээр хороо	343

15.	15 дугаар хороо	475
16.	16 дугаар хороо	766
17.	17 дугаар хороо	839
18.	18 дугаар хороо	1237
19.	19 дүгээр хороо	625
20.	20 дугаар хороо	1781
21.	21 дүгээр хороо	498
22.	22 дугаар хороо	536
23.	23 дугаар хороо	383
24.	24 дүгээр хороо	162
25.	25 дугаар хороо	113
26.	26 дугаар хороо	58
27.	27 дугаар хороо	3
28.	28 дугаар хороо	2
29.	29 дүгээр хороо	8
30.	30 дугаар хороо	7
31.	31 дүгээр хороо	8
32.	32 дугаар хороо	3
33.	33 дугаар хороо	3
34.	34 дүгээр хороо	1
35.	НИЙТ	26131

Хороодод ажиллах үйл ажиллагааны ерөнхий чиглэл

Мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн бүртгэл, мэдээллийг үндэслэн тухайн хороонд бүртгэлтэй 1-4 жил Техникийн хяналт, үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцож байгаа эсэхийг үл харгалзан байгаа байршил дээр нь нүд үзэн шалгах, тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, арал, хөдөлгүүрийн мэдээллийг холбогдох цахим систем (апликайшн)-д заасан үзүүлэлт тус бүрээр баталгаажуулан авч шинэчилсэн бүртгэл, тооллогод хамруулан сан үүсгэх, холбогдох хууль, журмын дагуу төлбөл зохих татвар, хураамжийг төлүүлэх, ашиглалтын шаардлагад нийцэхгүй болсон тээврийн хэрэгслүүдийг мэргэжлийн байгууллагад хандан хасалт хийлгэхэд оршино.

Татварын хэлтэс

- Тээврийн хэрэгсэл нь зарсан боловч албан ёсны шилжүүлэг хийлгээгүй, цаашид ашиглах боломжгүй болсон боловч албан ёсны хасалт хийлгээгүй, олон жилийн хуримтлагдсан өртэй тээврийн хэрэгслийн эзэмшигчидтэй биечлэн болон утсаар холбогдож, өрийн мэдээлэл, төлөх боломжуудыг танилцуулан тэмдэглэл хөтлөх;
- Төрийн өмчийн хорооны шийдвэрээр шилжилт хөдөлгөөн болон хасалт хийгдээгүйгээс болж өр үүсгэж бүртгэл дээрээ байгаа тээврийн хэрэгслүүдийн баримт бүрдүүлэх бүртгэлээс хасуулах, шилжүүлэх, үүссэн өр төлбөрийг барагдуулах;

- Төсөвт байгууллагуудын тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн шинэчлэн ОНӨГ-ын бүртгэлийг АТТ-ын бүртгэлтэй тулгаж, зөрүүг арилгах, татварын өртэй бол бүрэн төлж барагдуулах
- Татварын өрийг барагдуулан дүүргийн төсөвт бүрдүүлэх;

Цагдаагийн газар


- Гэмт хэрэг зөрчилд холбогдсон, журамлагдсан, саатуулагдсан тээврийн хэрэгслүүдийг тооллогод хамруулах ажлыг зохион байгуулах;
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэлд тусгагдсан үүрэг чиглэлийн дагуу сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангаагүй, төлбөрөө төлөөгүй, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг автозамын хөдөлгөөнд оролцохыг хориглох;
- Хороо хариуцсан хэсгийн байцаагч, зохицуулагч нарыг удирдамжид заасан байгууллагын чиг үүргийн дагуу ажиллуулах, тусгайлан үүрэгжүүлэх, ажлын явц гүйцэтгэлд өдөр тутмын хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах;

Дүүргийн Засаг даргын Тамгын газар

- Дүүргийн төсөвт байгууллагуудад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг бүртгэл тооллогод хамруулан мэдээллийг шинэчлэн мэргэжлийн байгууллагын бүртгэл мэдээлэлтэй тулгах татварын өртэй бол бүрэн төлж барагдуулах;
- Мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн, бүртгэл, мэдээллийг үндэслэн тухайн хороонд бүртгэлтэй 1-4 жил Техникийн хяналт, үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцож байгаа эсэхийг үл харгалзан байгаа байршил дээр нь нүд үзэн шалгах, тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, арал, үзүүлэлт тус бүрээр баталгаажуулан авч шинэчилсэн бүртгэл тооллогод хамруулах;
- Төрийн байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод хамруулах;
- Хороодын Засаг дарга нарт удирдамж тусгагдсан чиг үүрэгт ажлыг үр дүнтэй зохион байгуулж байгаа эсэхэд өдөр тутмын хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;
- Дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан ажлын тайланг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор Баянгол дүүргийн Автотээврийн төвд хүргүүлэх;

Хорооны Засаг дарга нар

- Жагсаалтад тусгагдсан тухайн багийн нутагт бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн байршил мэдээллийг урьдчилан бэлтгэж ажлын хэсгийг мэдээллээр хангах;
- Тухайн багт бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод бүрэн хамруулах;

- 
- Иргэдэд тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын талаарх мэдээ, мэдээллийг урьдчилан хүргэх;
 - Хорооны Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн гаргах, бүртгэлээс хасах шаардлагатай тээврийн хэрэгслүүдийн холбогдох баримт материалыг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;

Хугацаа

- 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Хороодын ажилласан ажлын тайлан нэгтгэн танилцуулах:

- Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу чиг үүрэг ажлын явц, гүйцэтгэлийг дүүргийн Засаг даргын орлогчид танилцуулж, гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, хороодод хүргүүлэх;